KONRAD ADENAUER STIFTUNG

Дэлхий даяарх хамруулалт

Улс орны мэдээ арай өөрөөр

Монгол Улс

kas.de

МОНГОЛ УЛС

Хүртээмжгүй бол оролцох боломжгүй

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд томоохон сорилтуудтай тулгардаг. Төр засгийн хүчин чармайлт болон олон улсын гэрээнүүдийг үл харгалзан тэдний улс төрд оролцох боломж нэлээд хязгаарлагдмал хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин дутмаг, дэмжлэг

Зураг 1: KASCAP 2024 оны оролцогчид

хомс, буруу ойлголтууд түгээмэл байдаг нь тэдэнд улс төрийн үйл явцад оролцоход хүндрэл учруулдаг. Ийм хэдий ч Д.Билгүүн болон Э.Дархийхүү нарын хүмүүс энэхүү саад тотгорыг даван туулах эрмэлзэл дүүрэн байна. Тэд хичээл зүтгэлээрээ Монголын ирээдүйд тэдний дуу хоолой мөн чухал үүрэгтэй гэдгийг нотолдог.

Хүсэл зориг дутаагүй

„Залуучуудын улс төрийн боловсрол ерөнхийдөө тааруу. Миний бодлоор залуучуудын зөвхөн 20 хувь л улс төрийн мэдлэгтэй“ гэж Д.Билгүүн өгүүлэв. Логистикийн менежерийн дээд боловсролтой тэрбээр төрөлхийн саажилттай бөгөөд энэ жил Конрад-Аденауэр-Сангийн “Олон нийтийн нөлөөллийн хөтөлбөр“-т (KASCAP) оролцсон. 2020 оноос эхлэн “Олон нийт улс төрд нөлөөлөх нь“ хөтөлбөр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг улс төрд оролцохыг дэмжиж ирсэн. Гол зорилго нь тэдний нийгэм болон улс төрийн идэвхийг бэхжүүлэх, манлайллын ур чадварыг эзэмшүүлэхэд оршдог. Нэг долоо хоногийн турш тэд төрөл бүрийн салбарын шинжээч, удирдах хүмүүстэй уулздаг билээ. Ингэхдээ тэд мэдлэг туршлага солилцож, тогтвортой харилцааны сүлжээ бий болгодог.

Нийгмийн үйл хэрэгт оролцох сонирхолгүй байдлаас улс төрийн боловсрол дутмаг гэж дүгнэж болохгүйг Д.Билгүүн онцолсон. Энэ байр суурийг 2023 онд Монгол Улсын Хүний эрхийн комиссоос явуулсан судалгааны үр дүн нотолдог. Улс төрийг 18-25 нас хүртэлх хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их сонирхдог. Асуулгад оролцсон хүмүүсийн 85.7 хувь нь УИХ-ын 2020 оны сонгуульд, мөн оны орон нутгийн сонгуульд 84.1, Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд 84.7 хувь нь саналаа өгсөн.

Энэхүү өндөр ирцэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлэх төрийн хүчин зүтгэл нөлөөлсөн. Тухайлбал, хараагүйчүүд бичгээр саналын хуудас бөглөх боломж бүрдүүлсэн, санал өгөх байруудыг томруулах шилээр хангасан бөгөөд сонгуулийн хэсгүүдэд нэвтрэн орох илүү таатай нөхцөл бүрдүүлсэн. Сонгуулийн хэсэгт очих боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгуулийн хороо зөөврийн хайрцгаар үйлчилж, гэртээ санал өгөх бололцоогоор хангасан.

Энэ мэт олон арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч сорилтууд тулгарсаар байна. Чөлөөтэй, нууц санал өгөх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд голлох хүндрэл хэвээр үлдсэн. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр асуулгад оролцсон хүмүүсийн 90 хувь нь бусдын дэмжлэггүйгээр санал өгөх боломжгүй байснаа хэлжээ. Ялангуяа оюун ухааны согогтой хүмүүст халамжлагчид нь нөлөөлөхийг хязгаарласан тодорхой эрх зүйн орчин үгүйлэгдэнэ.

УИХ-ын сонгуулийн олон хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид шаардлагатай тоноглол дутмаг, саадгүй орчны нөхцөл хангагдаагүй байсан. Үүнээс гадна улсын хэмжээний сонгуульд саадгүй нэвтрэх боломжтой санал өгөх тасалгаа, мэдээллийн самбарууд хуулийн дагуу шаардлагатай боловч орон нутгийн сонгуульд үүнийг зохицуулаагүй орхисныг үндэсний Хүний эрхийн комисс шүүмжилсэн. Энэ нь орон нутгийн сонгуулийн тэртээ, тэргүй бага ирцийг улам багасгахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гадуурхсан явдал юм. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хороо 2023 онд сонгуульд оролцохдоо дэмжлэг авах эрхийг баталгаажуулах тухай гэрээг илүү сайн хэрэгжүүлэхийг шаардсан билээ. Тийм хэдий ч үүнийг Монгол Улсын хууль тогтоомжид хангалтгүй тусгаж өгсөн байна.

Саад тотгорыг бүрэн арилгаагүй нь тусгаарлалтыг гүнзгийрүүлдэг

Саад тотгоргүй нөхцөлийг хангаагүй байдал болон зарим газрын маш муу дэд бүтэц, ялангуяа явган хүний зам нь өөр томоохон бэрхшээл болдог. “Муу дэд бүтэц нь бидний оролцоог хязгаарлах хамгийн том хүчин зүйлийн нэг“ гэж Д.Билгүүн өгүүлжээ. “Хамгийн тод жишээ нь шат юм. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст энэ нь олон тохиолдолд давашгүй саад болдог. Бүх шатыг налуу тавцангаар солих бодит боломж байхгүй. Гол асуудал нь ихэнх шат нь хэт огцом, бариулгүй баригдсанд оршдог“. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй төдийгүй нийтийн газраар зорчдог бүх хүнд эрсдэл учруулдаг. Норм, стандартуудын дагуу бусдын эрх ашгийг хамгаалж, хамгийн сайн шийдлийг санал болгох ёстой. Үүнийг Монгол Улсад тууштай нэвтрүүлж хянах ёстой.

“Архангай аймгийн хараат бус амьдралын төв“ ТББ-ын тэргүүн, KASCAP хөтөлбөрийн оролцогч ноён Э.Дархийхүү Д.Билгүүнтэй санал нэг байна. Тэрбээр мөн саажилттай бөгөөд нийгмийн амьдралд идэвхтэй оролцдог. Сүүлийн үед тэрбээр олон сургалт, арга хэмжээнд оролцсон бөгөөд муу зам харгуй, дутмаг дэд бүтэц нь нийгмийн амьдралд оролцох томоохон саад болохыг тэмдэглэсэн.

Зураг 2: KASCAP 2024 хэлэлцүүлэг

Нийтийн орон зайд нэвтрэх боломжгүй эсвэл хязгаарагдмал байдал нь Монгол Улсын хүн амын нэлээд хэсгийг ялгаварлан гадуурхахад хүргэж байна. Үндэсний статистикийн хороо мэдээлснээр 2023 оны сүүлээр Монголд хөгжлийн бэрхшээлтэй 111 200 хүн амьдарч байсан бөгөөд энэ нь нийт хүн амын ойролцоо 3.1 хувь гэсэн үг. Герман эсвэл Австри зэрэг улстай харьцуулахад энэ бага хувь хэмжээ нь төрийн статистик бодит амьдралаас зөрүүтэй байж болзошгүйг харуулдаг.

Энэ хүмүүсийн амьдралын чанар, оролцоог сайжруулахын тулд Монгол Улс сүүлийн жилүүдэд хуулиудаа шинэчилсэн ба шинэ бүтцүүдийг бий болгосон билээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хуулийг 2013 онд баталж, улмаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн ерөнхий газар 2018 онд байгуулагдсан явдал нь энэ чиглэлийн чухал алхам болсон. Олон аймагт тусгай хөгжлийн төвүүдийг шинээр нээжээ.

Энэхүү дэвшлийг үл харгалзан нөхцөл байдал хүнд хэвээрээ үлдсэн. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн ихээр тусгаарлагдсан нийгмийн бүлэгт тооцогдсон хэвээр байна. Шинжлэх ухааны академийн Гүн ухааны хүрээлэнгийн 2013 онд хийсэн судалгааны дагуу тэдний хязгаарлалтын түвшин нь 42.9 хувьтай байсан бөгөөд энэ нь тухайн өрхийн хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс 23.3, бусад хүн амын бүлгүүдийн дунджаас 28.1 хувиар илүү байна.

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээнд нэгдсэн боловч бодит амьдрал дээр байдал өөр дүр төрхтэй байна. Олон хүн өнөөдөр ч эрх тэгш нийгмийн амьдралд оролцох боломжгүй хэвээр. Эрх зүйн зохицуулалт байгаа боловч олон тохиолдолд оролцоог зүй ёсоор хангах бодит хэрэгжүүлэлт, шаардлагатай нөөц, хэрэгслүүд дутмаг байна.

Парламентын төлөөлөл бүх асуудлыг шийдвэрлэх хэрэгсэл

Монголын Засгийн газрын зүгээс асуудлыг шийдэх нэг оролдлого нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн парламент дах төлөөллийн хувь хэмжээг нэмэгдүүлэх юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах гэрээг хэрэгжүүлэх тухай хэлэлцүүлэгт хууль тогтоомжийг өөрчлөх, тэр дундаа ялангуяа улс төрд оролцохыг дэмжих арга хэмжээнүүдийг зөвлөмж болгосон. Үүнд сонсгол, хараа болон оюун ухааны бэрхшээлтэй иргэдийг дэмжих, жижиг намуудын нэр дэвшигч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслалцаа үзүүлэхийг онцолж байв.

УИХ-ын 2024 оны сонгуулиар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу анх удаа 126 гишүүн сонгогдсон билээ. Ингэснээр нийгмийн төрөл бүрийн бүлгүүд парламентад илүү төлөөлөлтэй болох хүлээлт үүссэн. 78 гишүүнийг мажоритар, 48 гишүүнийг пропорциональ системээр сонгосон. Эрх баригч Монгол ардын нам хөдөлгөөний бэрхшээлтэй, “Ахилис” ТББ-ын гүйцэтгэх захирал О.Саранчулууныг өөрийн намын жагсаалтын дөрөвт нэр дэвшүүлснээр эрэг хандлага үзүүлсэн. Арчилсан нам тэргэнцэртэй жүжигчин Ж.Баясгаланг жагсаалтын долоод нэр дэвшүүлсэн. Тэд хоёулаа УИХ-д сонгогдсон ба Монголын хууль тогтоох байгууллагын анхны хөгжлийн бэрхшээлтэй гишүүд болсон билээ.

Нэр дэвшүүлсэн нь алсын бодолтой хийгдсэн байж болзошгүй. Учир нь 2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулиар парламентад амжилттай сонгогдсон хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийн намд илүү их хэмжээний санхүүгийн дэмжлэг олгогдохоор болсон. Харамсалтай нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн идэвхийг дэмжих олон зөвлөмжийг хуульд тусгаагүй юм. Үүнд төрөөс дэмжлэг үзүүлэх хөрөнгийн 20 хувийг нэн эмзэг бүлгүүдийг бэхжүүлэхэд зарцуулах амлалт байсан. Мөн тодорхой заалтуудаар “жижиг” гэгдэх намуудаас нэр дэвшигч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих бодлого талаар өнгөрсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог дэмжих, ялангуяа сонгуулийн эрх зүйг зохицуулах олон тооны хууль, журам зааврын үйлчилгээ хүлээсэн үр дүнд хүрэхгүй байна. Хэрэгжилтийг хянах, зөрчсөн үед

хариуцлага ногдуулах тогтолцоо үгүйлэгдэж байна. Оролцоог дэмжих улс төрийн намуудын арга хэмжээнүүд зөвхөн хэлбэр төдий хэрэгжиж, тодорхой удирдагч эсвэл нөлөө бүхий улс төрчийн санаачилгаас ихээхэн хамаардаг. Эцсийн бүлэгт намын жагсаалтаар нэр дэвших нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд УИХ-д сонгогдох ганц бодит боломж юм. Тойрогт нэр дэвших боломж ихээхэн хомс билээ.

Тойрогт нэр дэвших нь санхүүгийн хувьд боломжгүй

Үүний гол шалтгаан нь санхүүгийн өндөр ачаалал юм. Сонгуулийн зардлын тодорхой хэсгийг өөрөө хувиараа хариуцахыг хуулиар зөвшөөрсөн ба намуудын тогтоосон босго 300 000 еврог давна. Энэ нь Монголд ихэнх хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төсөөлшгүй их мөнгө юм. Энэ асуудлыг зохицуулахын тулд үндэсний Хүний эрхийн комисс 23 дугаар тайландаа бүх сонгуулийн шатанд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдийг зөвлөсөн. Үүнд сурталчилгааны материал, зориулалтын автомашин, самбаруудын санхүүжилт, дохионы хэлмэрч болон хувийн туслахуудын дэмжлэг багтсан.

Засгийн газар санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нөхөн олговор олгох болон татварын хөнгөлөлтийг хуулиар зохицуулахыг төлөвлөсөн боловч өнөөг хүртэлх маш удаан хэрэгжилтийн улмаас энэхүү төлөвлөгөө биелэх, эсэх нь эргэлзээтэй.

Саадгүй нөхцөл байдал бүтэшгүй “Мөрөөдөл“ үү?

Сонгуулийн хэсэгт очих, санал өгөх боломж бий болсон ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд улс төрд оролцох бололцоо нь ихээхэн хязгаарагдмал хэвээр байна. Саад тотгоргүй дэд бүтэц, хүртээмжтэй нийтийн тээвэр, иж бүрэн мэдээлэл болон эрх тэгш өрсөлдөөн учир дутагдалтай хэвээрээ. 2006 оноос эхлэн олон нийтийн байгууллагын өрөө тасалгаа, байранд саад тотгоргүй нэвтрэх тухай хэлэлцүүлэг өрнөж байгаа. Гэвч хангалтгүй хэрэгжилт, хяналтгүй байдал болон нийгмийн томоохон хэсгүүдийн үл томсоорлох явдал нэгэнт баталсан хууль стандартуудыг үр дүнгүй болгодог. Өдөр тутмын саад бэрхшээлүүд хуулиар заасан эрхүүдийг бүтэшгүй “мөрөөдөл“ мэт санагдуулдаг.

Сэтгэл санааны хязгаарлалтыг устгах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд хангалтгүй төлөөллийн өөр нэгэн шалтгаан нь нийгэм тэднийг хэрхэн хүлээн авдагт оршдог. Олон нийтээс тусгаарлагдсан, ховор харагдах тул Монголд олон хүн бусдын бэрхшээлтэй тулгарч үзээгүй, үүнтэй харьцах туршлагагүй байдаг. Энэ нь хэвшмэл буруу ойлголтуудыг төрүүлдэг.

Олон тохиолдолд хүмүүс биеийн хөгжлийн бэрхшээлтэй хүний оюун ухааны чадварт эргэлздэг. Энэхүү эргэлзээ нь улс төрийн дутмаг мэдлэг, бодит харилцааны туршлагагүй байдалтай зэрэгцэн нэрвэгдсэн олон хүний өөртөө итгэх итгэлийг сулруулдаг. Гэтэл чухам энэ итгэл нь нийгэм, улс төрд оролцоход голлох ач холбогдолтой. Тиймээс энэхүү өөртөө үл итгэх байдлыг даван гарч, улс төрийн идэвх гаргахын тулд ноён Д.Билгүүн KASCAP хөтөлбөрт оролцохоор шийдсэн.

Дэлхий *даяарх* хамруулалт: Улс орны мэдээ арай өөрөөр• Монгол Улс

Зураг 3: KASCAP 2024 Хаалтын арга хэмжээ

Энэ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд итгэл урам өгч, мэдлэг туршлага олгохын зэрэгцээ харилцааны сүлжээ бий болгодог. Зөвхөн асуудалд өртсөн хүмүүс өөрсдөө идэвхтэй оролцож, оршиж буй дутагдлуудыг засаж залруулах боломжтойг энэ хөтөлбөр харуулна. КАС болон бусад гадаадын байгууллагууд тусламж үзүүлэх боловч өөрийн идэвх зүтгэлийг юу ч орлох боломжгүй билээ.

Үүнийг ноён Э.Дархийхүү хүлээн зөвшөөрдөг. Өөрийн ТББ-аар дамжуулан тэрбээр бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд улс төрд оролцох сонирхол төрүүлдэг. Монгол Улсын хөгжил тэдний оролцооноос мөн хамаарах юм.

Хэвлэлийн мэдээлэл

Конрад-Аденауэр-Сан ТББ
Виктор Франк
Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын дарга
viktor.frank@kas.de

Хамтран зохиогч: Б.Номин

kas.de

Нийтлэгч: Konrad-Adenauer-Stiftung e. V., 2024, Berlin
Өрөлт: Marianne Graumann, Konrad-Adenauer-Stiftung e. V.
Зураг: Konrad-Adenauer-Stiftung Mongolei

Энэхүү Конрад-Аденауэр-Сангийн нийтлэл зөвхөн мэдээллийн зорилготой. Үүнийг аливаа нам, сонгуулийн ухуулагч эсвэл туслах сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглоно. Энэ нь Бундестаг, муж улсын парламент болон орон нутгийн сонгууль, Европын Холбооны парламентын сонгуульд адил үйлчилнэ.

Энэхүү нийтлэлийн текстэнд зохих лиценз олгосон болно. „Creative Commons Namensnennung-Weitergabe unter gleichen Bedingungen 4.0 international", CC BY-SA 4.0 (abrufbar unter: https://creativecommons.org/licenses/by-sa/4.0/legalcode.de)